



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ – 2018

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

- 2019 оны 01 дүгээр сарын 24-25-ны өдөр
- ШУА-ийн Нэгдсэн I байрны 410 тоот хурлын танхим
Улаанбаатарын Их Сургуулийн хурлын танхим

Зохион байгуулагч:

Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхим
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн

Оролцогч байгууллагууд:

МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим
Монголын Үндэсний Музей
ШУТИС-ийн БУХС-ийн Хүмүүнлэгийн салбар
Нүүдлийн Соёл Иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Соёлын Өвийн Үндэсний Төв
Ховд Их Сургууль

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ-2018 ОН

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

Ерөнхий редоктор: Д.Эрдэнэбаатар
Эрхлэн нийтлүүлсэн: Ч.Амартүвшин
Ж.Эрдэнэ
Хэвлэлд бэлтгэсэн: Ж.Эрдэнэ
Д.Цэнд

Цаасны хэмжээ: 176x250 мм
Хэвлэлийн хуудас: 32.3 х.х
Хэвлэсэн тоо: 300 ш

“Бемби сан” хэвлэх үйлдвэрт хэвлэв.



ГАРЧИГ

- 1 Б.Гүнчинсүрэн, Д.Базаргүр, А.М. Хаценович, Е.П. Рыбин, Д.В. Олсен, Д.В. Марченко, С.А. Когай, А.С. Кравцова, Р.А. Шелепаев, А.Ю. Попов, Я.Ю. Шелепов, Т.А. Шевченко. Орхоны хөндийн чулуун зэвсгийн дурсгалуудад хийсэн судалгаа – 2018. (Орхон -1, Мойлтын ам) 9
- 2 Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Г.Лхүндэв, Д.Одсүрэн, Г.Ангарагдөлгөөн, Н.Звинс, М.Изухо, К.Пэйн. Төлбөр-17 палеолитын дурсгалт газарт 2018 онд хийсэн малтлага судалгааны тухай 15
- 3 Д.Базаргүр, Г.Лхүндэв, Албан Дефлиор. Горхи-Тэрэлжийн сав газарт хийсэн археологийн мэдээ шалгах, тандалт судалгаа: Агуйт хадны чулуун зэвсгийн дурсгалын малтлага 22
- 4 Д.Одсүрэн, Л.Яанз, Д.Бөхчулуун. Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын тухай 27
- 5 Я.Цэрэндагва, Ж.Фаркухар, С.Далантай, Р.Төрбат, Х.Элскен. Их нартын чулуунд ажилласан Монгол-Америкийн хамтарсан экспедицийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн 35
- 6 Ч.Амартүшин, У.Ханичёрч, З.Батсайхан, У.Эрдэнэбат, Ж.Врайт, Ш.Гидеон, Д.Одсүрэн, Г.Галдан, Б.Батдалай, Б.Бөхчулуун, Д.Мандах, О.Батзориг, А.Камерон, А.Орхонсэлэнгэ, С.Плэутэр, В.Вилсон, Ц.Цэлхагарав, М.Алтаншагай, С.Рамшлэг, Ж.Фэнг. Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны судалгааны товч үр дүн 41
- 7 Ж.Баярсайхан, Жан-Лүүк Хюл, Оула Сейцонин, Ч.Баяндэлгэр, Наталья Эгүз. Монгол-Америкийн хамтарсан “Баруун Монгол” төслийн 2018 оны хээрийн судалгааны товч үр дүн 49
- 8 Ю.Болдбаатар, Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, Г.Очирболд. ШУТИС-ийн БУХС-ийн археологи угсаатны зүйн судалгааны багийн Баянхонгор аймгийн Баян-овоо, Өлзийт, Жинст сумдад явуулсан хайгуул судалгаа 53
- 9 Т.Идэрхангай, Д.Цэнд, Б.Амгаланбат, Б.Батчимэг. Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутаг дахь Салхит ууланд явуулсан хадны зургийн судалгаа 56
- 10 З.Батсайхан, С.Тэргүүнбаяр, Ч.Амарбилиг, Д.Содномжамц, Б.Дашзэвэг. Монгол-Хятадын хамтарсан “Монгол нутаг дахь археологийн малтлага судалгаа” төслийн хүрээнд Чулуун онгоцот, Тахилга уулын хадны зургийн судалгааны урьдчилсан үр дүн 61
- 11 Ю.Болдбаатар, Д.Хатанбаатар, Ц.Бямба-Очир, С.Бат-Эрдэнэ Булган аймгийн Тэшиг сумын Харгал нуурын орчимд хийсэн хадны зосон зургийн хайгуул судалгаа 64
- 12 З.Батсайхан, Ч.Амарбилиг, Д.Содномжамц, С.Тэргүүнбаяр, Пан Лин, Ван Лисин, Даландөрөв. Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” археологийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны хайгуул, малтлага судалгааны ажлын товч үр дүн 66
- 13 Ч.Мөнхбаяр, А.А.Ковалев, Ц.Буян-Орших, Д.Сүхбаатар. Монгол-Оросын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Их хулагаш, Ямаатын голын археологийн дурсгалын судалгаа 70
- 14 Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, У. Бросседер. Монгол-Германы хамтарсан “Баркор” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн 87



15	Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Магай. Монгол-Монакогийн хамтарсан “Хойд Тамир-Хүнүй” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн	91
16	Д.Эрдэнэбаатар, Э.Мижиддорж, Б.Галбадрах, Ж.Эрдэнэ, Жоу Ли Ган, Лю Бин, Ни Фен, Рей Шан. Монгол-Хятадын хамтарсан “Хүрэл-төмрийн үеийн нүүдэлчдийн археологийн дурсгал” төслийн 2018 оны Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хануй багийн нутагт ажилласан археологийн малтлага судалгаа	94
17	З.Батсайхан, Ч.Амартүвшин, Д.Содномжамц, Б.Батдалай, Б.Батзориг. Төв аймгийн Лүн сумын Оорцог ууланд хийсэн археологийн судалгааны товч үр дүн	99
18	Б.Анхбаяр, Ц.Амгалантөгс, Ц.Болорбат, Г.Батболд, Цао Жиан эн, Сүн Гүо дүн. Монгол улс, БНХАУ-ын хамтарсан археологийн судалгааны 2018 оны ажлын товч үр дүн (Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт хийсэн археологийн судалгаа)	103
19	Г.Эрэгзэн, С.Энхболд, П.Алдармөнх, У Жэ жин, Ан Жэ пил. Төв аймгийн Баянцагаан сумын нутагт ажилласан Монгол-Солонгосын хамтарсан ангийн археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын үр дүнгээс	111
20	Ц.Мөнхбат, Ч.Энхтөр. Ховд аймгийн нутгаас 2018 онд шинээр илэрсэн хадны зураг дахь тэрэгний дүрслэлүүд	117
21	Н.Батболд, Д.Батсүх, Н.Баярхүү, Б.Өмирбек, Жон Сон Муг. Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн 2018 оны судалгааны үр дүн	123
22	Ю.Болдбаатар, Г.Анхсанаа, Д.Хатанбаатар. Богд хан уул орчимд хийсэн хайгуул судалгаа	129
23	Г.Анхсанаа, Д.Нямдорж, П.Чинбат, А.Мөнгөнцөөж. Соёлын өвийн үндэсний төвөөс Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор дурсгалд ажилласан хээрийн судалгаа	134
24	Монгол-Оросын хамтарсан “Төв азийн археологийн шинжилгээ-1” төслийн Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт явуулсан малтлага судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс	140
25	Ч.Амартүвшин, Л.Эрдэнэболд, Б.А.Биликто, М.А.Денис, Д.Хатанбаатар, Р.Төгссайхан, Б.Батдалай. ОХУ-ын Улаан-Үүд хотын орчимд буй хүрэл зэвсгийн үеийн археологийн дурсгалуудтай танилцсан тухай	147
26	Т.Идэрхангай, С.Оргилбаяр, А.А.Гишкин, Н.Н.Серегин, Д.Цэнд, Б.Батчимэг, Б.Амгаланбат, П.Эрдэнэпүрэв. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийд явуулсан археологийн малтлага судалгаа	150
27	Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн, Г.Галдан, Ц.Цэлхагарав, Т.Сасада, И.Үсүки, Т.Сагава, Х.Үчида, Т.Шёожи, Т.Янагимото, Д.Накамүра. Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын үйлдвэрлэлийн түүх” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2018 оны товч үр дүн	156
28	Д.Эрдэнэбаатар, Э.Мижиддорж, Б.Галбадрах, Ж.Эрдэнэ. Улаанбаатарын их сургуулийн Археологийн тэнхимийн суурь судалгааны төслийн 2018 оны үр дүнгээс	161
29	Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд, А.Амарболд, Ц. Эгиймаа, Жан Өнжон, И На гён. Мон-Сол төслийн хүрээнд Дуурлиг нарсны дурсгалт газарт 2018 онд хийсэн судалгааны үр дүнгээс	166



- 30 Г.Эрэгзэн, С.Энхболд, П.Алдармөнх. “Хүннүгийн хот суурин, үйлдвэрлэлийн түүхийн судалгаа” суурь судалгааны төслийн хүрээнд 2018 онд явуулсан археологийн хээрийн судалгааны ажлын үр дүнгээс 171
- 31 Ц.Одбаатар, Б.Амгаланбат, И.Будбаяр. “Монгол-Хятад”-ын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Төв аймгийн Цээл сумын Шийгэрт явуулсан археологийн судалгааны танилцуулга 178
- 32 Л.Эрдэнэболд, Ч.Ванчигдаш, З.Одбаяр. Бишрэлтийн амны хүннүгийн жирийн иргэдийн оршуулгын бүлэг дурсгалд 2018 онд хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс 184
- 33 Ж.Цамбагарав, А.Энхтөр, Л.Шинэбат, Т.Батбаяр, Л.Мөнхбаяр, Б.Дэжидмаа, Г.Батболд. Хархорин сумын нутагт дахь Дунд булгийн амны хүннүгийн булшны малтлага судалгаа 189
- 34 А.Очир, С.Хүрэлсүх, Г.Мандахбаяр, Чен Ён Жи, Саранбилэг, Чэн ПенФей. Монгол-Хятадын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Архангай аймгийн Өгийнуур сумын Талын гурван хэрэмд 2018 онд малтсан судалгааны ажлын товч үр дүн 195
- 35 Ч.Амартүвшин, Я.Мүраками, Л.Ишцэрэн, Г.Галдан, Н.Амитан, Ж.Брайс, Ж.Жонхө. Алтайн бүс нутагт ажилласан Монгол-Японы хамтарсан төслийн урьдчилсан үр дүнгээс 207
- 36 Л.Ишцэрэн, К.Кияма, Т.Саада, М.Сагава, Т.Осава, Л.Мөнхбаяр, Ц.Амгалантөгс, Б.Эрдэнэ. Монгол-Японы хамтарсан хээрийн шинжилгээний ангийн Улз голын хөндийд хийсэн археологийн хайгуул, малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс 214
- 37 Ц.Одбаатар, Б.Даваацэрэн, М.Нямбат, М.Барс, Г.Энхбаяр “Монгол-Хятадын хамтарсан Айрагийн гозгор дахь эртний нүүдэлчдийн археологийн судалгаа” төслийн 2018 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн 221
- 38 С.Өлзийбаяр, Б.Батсүрэн, Б.Очир, Э.Уртнасан. “Хүннүгийн дараах нүүдэлчид - 2018” хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс 227
- 39 Т.Идэрхангай, А.А.Тишкин, В.В.Горбунов, Н.Н.Серегин, Б.Өнөрбаяр, Д.Цэнд, Б.Батчимэг, П.Эрдэнэпүрэв. Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ-2” хээрийн шинжилгээний ангийн Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутагт ажилласан малтлага судалгааны ажлын үр дүнгээс 231
- 40 Ц.Одбаатар, Ц.Эгиймаа, Ч.Баяндэлгэр, Акедил Тойшанулы, Олжас Шариязданов. Хаяа худаг, Гүн бүрд дэх түрэгийн тахилын онгонд хийсэн археологийн малтлага судалгаа 237
- 41 А.Энхтөр, Д.Цэвээндорж, С.Далантай, Ц.Буянхишиг, Д.Кыдырали, Б.Напил, Н.Бөгөнбаев. Олон улсын хамтарсан “Шивээт улаан” төслийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн 242
- 42 А.Энхтөр, Р.Мөнхтулга, С.Далантай, Ц.Буянхишиг, Д.Кыдырәлі, Н.Базылхан, Н.Бөгөнбаев. 2018 онд Хөшөө Цайдамд Монгол-Казахстаны хамтарсан хээрийн шинжилгээний ангийн гүйцэтгэсэн археологийн судалгааны ажлын урьдчилсан үр дүн 247
- 43 Ю.Болдбаатар, Л.Эрдэнэболд, Д.Хатанбаатар, Г.Анхсанаа, З.Одбаяр. Төв аймгийн Баян-Өнжүүд сумын нутаг, Улхын буланд ажилласан археологийн судалгааны ажлын товч тайлан 250
- 44 У.Эрдэнэбат, К.Франкен, Т.Батбаяр, Х.Рооланд. Уйгурын нийслэл Хар балгасанд 2018 онд Монгол-Германы Орхон экспедицийн хийсэн малтлага судалгаа 254



**МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН “ТӨВ АЗИЙН АРХЕОЛОГИЙН
ШИНЖИЛГЭЭ-2” ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН НУТАГТ АЖИЛЛАСАН
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС**

*Т.Идэрхангай, А.А.Тишкин, В.В.Горбунов, Н.Н.Серегин,
Б.Өнөрбаяр, Д.Цэнд, Б.Батчимэг, П.Эрдэнэпүрэв*

Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутаг Чигэртэй голын сав, түүний нэгэн салаа болох Хүрээ зуслан хэмээх газарт Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 260/А тоот тушаалаар Монгол-Оросын хамтарсан “Төв Азийн археологи-2” төслийн хээрийн шинжилгээний анги 2018 оны 08 сарын 05-наас 25-ныг хүртэл хугацаанд археологийн малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэх албан ёсны зөвшөөрлийн дагуу Түрэгийн үеийн тахилга тайлгын 2 дурсгалыг малтан Монгол улсын эртний түүх, тэр дундаа Түрэгийн үеийн түүхийг гүнзгийрүүлж, нарийвчлан судлах боломж бололцоог бүрдүүлэхийн зэрэгцээгээр Евразийн Түрэгийн үеийн тахил тайлгын байгууламжийн хувьсал өөрчлөлт, он цагийн ялгаа хийгээд орон нутгийн хэв шинжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой судалгааны эх хэрэглэгдэхүүнийг илрүүлэн олж судалсан болно.

Бид энэхүү судалгааны ажилтай уялдуулан БСШУСЯ-ны археологийн малтлага судалгаа явуулах албан ёсны зөвшөөрлөөс гадна БОАЖЯам, Хил Хамгаалах Ерөнхий Газруудаас авсан албан ёсны зөвшөөрлийг Баян-Өлгий аймгийн төв дэх Монгол Алтайн Нурууны Улсын Тусгай Хамгаалалтын Газрын Захиргааны эрдэм шинжилгээний ажилтан М.Жуханд бүртгүүлэн тус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулав. Түүнчлэн бид Алтай сумын Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч О.Сакен нарт археологийн малтлага судалгаа хийх тухайгаа танилцуулснаар бидний ажил албан ёсоор эхэлсэн билээ.

Судалгааны ангийн бүрэлдэхүүн

Уг хээрийн судалгааны ангид Монгол улсын Улаанбаатарын Их сургуулийн болон ОХУ-ын Барнаул хотын Алтайн Улсын Их сургуулийн Археологи, Угсаатан, Музей судлалын тэнхимийн эрдэмтэн судлаачдын хамтарсан баг ажилласан болно. Үүнд: Монголын талаас Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) Т.Идэрхангай, тэнхимийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Цэнд, Б.Батчимэг, Хэнтий аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Б.Өнөрбаяр, Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн 2016 оны төгсөгч Улаанбаатар хотын Эрдмийн Ундраа цогцолбор сургуулийн түүхийн багш П.Эрдэнэпүрэв, Оросын талаас Барнаул хотын Алтайн Улсын Их Сургуулийн Археологи, Угсаатан, Музей судлалын тэнхимийн эрхлэгч, доктор (Sc.D), профессор А.А.Тишкин, тэнхимийн ахлах багш, доктор (Sc.D) В.В.Горбунов, тэнхимийн багш, доктор (Ph.D) Н.Н.Серегин, тэнхимийн багш, доктор (Ph.D) Т.С.Паршикова, тэнхимийн багш, доктор (Ph.D) О.С.Лихачева, тэнхимийн магистрант С.С.Радовский, ОХУ-ын судалгааны ангийн жолооч А.Н.Толмачев нарын нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа.



Чигэртэй гол

Алтай сумын төвөөс баруун хойш орших ертөнцийн зүгээр зүүн урагш харсан нэгэн жижиг амыг Чигэртэй хэмээх бөгөөд энэхүү ам, хөндийгөөр Чигэртэй гол урсана. Чигэртэй гол нь Чигэртэй нуураас эх аван Алтай сумын төвийн урдуур урсах Сагсай голд цутгана. Энэхүү Чигэртэй голын хөндийгөөр 2006 онд Монгол Алтай Судлалын Хүрээлэнгээс зохион байгуулсан “Монгол Алтайн баруун хэсгийн археологийн дурсгалууд-1” төслийн хүрээнд археологийн хайгуулын ажлыг явуулж үе үеийн олон дурсгал илрүүлэн олсны дотор Түрэгийн үеийн 7 дурсгалт газарт нийт 39 тахил тайлгын дурсгалыг¹ илрүүлж байсан болно. Түүнчлэн Чигэртэй голын зүүн талын салаа Хүрээ зуслангаас Түрэгийн үеийн нийт 12 тахил тайлгын дурсгалыг² илрүүлэн олж байв.

Бид 2018 онд БСШУСЯ-наас Чигэртэй голын савд өргөн цар хүрээтэй археологийн малтлага судалгаа хийх зөвшөөрлийг авсан бөгөөд малтан судлах дурсгалт газрын координат буюу байршлын солбилцлыг тодорхой дурсгал дээр авах шаардлагатайг бодолцон Чигэртэй голын эх, голын баруун талын хүн чулуу бүхий 20 орчим тахилын байгууламжтай дурсгалт газарт болон Хүрээ зуслангийн 12 тахилын онгоны солбилцлыг зөвшөөрөл дээр бичүүлсэн болно. Гэвч бид 2018 оны 08 сарын 07-нд Алтай сумын Чигэртэй голын баруун талын хүн чулуутай тахил, тайлгын цогцолбор бүхий 20 орчим дурсгал дээр ирж малтлага судалгааны ажлаа эхлүүлэх гэсэн боловч Чигэртэй гол ус их үертэй нааш цааш явахад хүндрэлтэй байсан учир арга буюу Хүрээ зусланд малтлага судалгаага хийхээр Оросын талын удирдагчтайгаа тохиролцон 3 дахь солбилцол болох Хүрээ зуслангийн дурсгалт газарт ирж малтлагын отогоо байгуулсан билээ.

Хүрээ зуслангийн малтлага судалгаа

Бид 2018 оны 08 сарын 07-ны орой Хүрээ зуслан хэмээх дугуйрсан жижиг тойрог бүхий нарийн өвс бүхий өлөнтэй газрын зүүн урд талын өндөрлөг дэнжид байх Төмрийн түрүү үеийн Пазырькийн соёлын булшнууд болон түүний эргэн тойронд орших 12 тахил, тайлгын онгон бүхий Түрэгийн үеийн дурсгалт газартаа ирж дурсгалуудтайгаа танилцан үзсэний дараагаар тэдгээр дурсгалуудын ар дор буюу Хүрээ зуслангийн гол хэмээх жижиг горхины хоёр талаар отогоо байгуулан товхинож амжлаа.

2018 оны 08 сарын 08-ний өглөө эртлэн босч цайгаа уугаад нар ташсан нарны гэрлийн тусгал болох гэрэл сүүдэр ихээхэн зохицсон байсан тул нисдэг камер буюу дроноо нисгэн тухайн дурсгалт газрын ерөнхий зургийг авч баримтжуулав. Баримтжуулалт хийсний дараагаар зүүн хойноос баруун урагш цуварсан 4 пазырык булшны урд байрлах усан татаал шуудуу бүхий язгууртны гэмээр мөртлөө хүн чулуу, зэл чулуутгүй нэгэн өвөрмөц бүтэц бүхий тахилын байгууламжийг сонгон малтан судлахаар болов. Мөн энэхүү язгууртны тахилын онгоны зүүн урд талд орших нэгэн жижиг жирийн иргэдийн тахилын онгоныг малтахаар тогтов.

Язгууртны тахилын онгоны малтлага судалгаа. Хүрээ зуслан хэмээх энэхүү газарт Төмрийн түрүү үе болон Түрэгийн үеийн олон дурсгал хоорондоо зайтай 3 хэсэг газарт бүлэг үүсгэн оршино. Бидний малтлага судалгаа явуулсан

¹ Ц.Төрбат, Д.Баяр, Д.Цэвээндорж, Ц.Баттулга, Н.Баярхүү, Т.Идэрхангай, П.Х.Жискаар. Монгол Алтайн археологийн дурсгалууд-1, Баян-Өлгий аймаг. Улаанбаатар, 2009, т. 199-200

² Мөн тэнд, 201




газарт зүүн хойноос баруун урагш чиглэн цуварсан 4 пазырык булш, Түрэгийн үеийн язгууртны тахилын байгууламж 1, жирийн иргэдийн тахилын онгон 13, жижиг дугуй тахилын байгууламж 7, дугуй хэлбэрийн чулуун байгууламж 1 нийт 24 дурсгал бий (Зураг 1). Эдгээрээс язгууртны тахилын байгууламжаа №1 хэмээн дугаарлан малтлагын ажлыг явуулав.


Дурсгалыг хөндөхөөс өмнө гэрэл зургаар баримтжуулан хэмжилт хийсний дараагаар тахилын байгууламжийн төв хэсгээр дайруулан хойноос урагш, зүүнээс баруунш огтолцсон хөндлөн огтлолын хамрыг 20 см өргөн үлдээж, дурсгалын усан татаал шуудууг бүрэн багтаан 12 x 12 м хэмжээтэй малтлагын талбайгаар өнгөн хөрсний цэвэрлэгээний ажлыг хамгийн гүн хэсэгт 30 см, гүехэн хэсэгт 10 см явуулахад дурсгалын үндсэн зохион байгуулалт тодорхой мэдэгдэв. Уг тахилын байгууламжийг гүйцэтгэхдээ төв хэсэгт нь шороон довцог байгуулж түүний дээр чулуугаар тахилын дөрвөлжин хашлага маягийн байгууламж үйлдсэнийгээ тойруулан газар ухан шуудуу татаж шуудуугаа том жижиг хавтгай чулуугаар шаллан хамгаалалтын системийг хийж байсан нь тодорхой болов. Усан татаал шуудууны гадна талд шуудууг ухахад гарсан шорооны үлдэгдэл 2-5 см өндөр далан маягийн шорооны үлдэгдэл сайтар ажиглавал бий. Малтлагын явцад дурсгалын төв болон зүүн хойд талбайгаас нимгэн болон зузаан саарал шавраар хийсэн шаар сав суулгын хагархайнууд болон адууны шүднүүд илэрч байв (Зураг 2-4).

Жирийн иргэний тахилын онгоны малтлага. Бид язгууртны тахилын онгоныг малтахын зэрэгцээгээр түүний зүүн урд байсан дөрвөлжин хашлага бүхий жижиг тахилын онгоныг сонгон малтан судаллаа. Уг тахилын хашлагыг дэвсгэр зурагт №14 хэмээн тэмдэглэсэн болно.

Тахилын онгоныг малтан судлахаас өмнөх үеийн гэрэл зургийн баримтжуулалт болон хэмжилтийг хийсний дараагаар тахилын онгоны төв хэсгээр дайруулан хойноос урагш чиглэсэн 20 см өргөн хөндлөн огтлолын хамрыг татахын зэрэгцээгээр тахилын онгоныг бүрэн багтаан баруунаас зүүнш 4 м, хойноос урагш 4.5 м хэмжээтэй талбайгаар цэвэрлэгээний ажлыг 8-10 см гүнээр эхлүүлэв. Цэвэрлэгээний явцад ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илэрсэнгүй. Харин уг тахилын онгоны үндсэн зохион байгуулалт тодорхой мэдэгдэв. Тахилын онгоны өмнө талд хоёр эгнээ ээл чулууг босгосон нь хойд талдаа 2 ширхэг, урд талдаа 1 байна. Түүнчлэн тахилын хашлаганы баруун талд нааж байгуулсан зэрэгцээ 2 жижиг хашлаганы ирмэг мэдэгдэж байв. Учир иймд цэвэрлэгээний дараах байдлын бүх баримтжуулалтыг хийж дуусаад тахилын хашлаганы гадна болон дотор талд дүүргэн үйлдсэн жижиг чулуудыг авч цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэлээ. Бид үндсэн том тахилын хашлагаа 1, түүний баруун талаас шинээр илэрсэн 2 жижиг хашлагыг урд талаас нь нэмж 2, 3 хэмээн дугаарлав. Үндсэн том хашлаганы төв хэсгийн цэвэрлэгээнээс хонины асуудаг ууцны төгсгөлийн 1 нугалам, шавар ваарны хагархай 1 илрэв. Түүнчлэн том хашлаганы төв хэсэгт 2 том хавтгай чулуу илрэв. Энэ үеийг баримтжуулсны дараа 2 том чулууг хуулж цэвэрлэхэд урд талын том хавтгай чулууны доороос жижиг толбо илэрсэн тул толбоор малтлагыг доош 15 см гүнээр үргэлжлүүлэхэд шатсан модны үйрмэг гарав. 2 болон 3-р хашлаганаас шатсан модны нүүрс, шатсан ясны үйрмэг илрэв. Өөр ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдоогүй болно (Зураг 5). Малтлагын ажил дууссаны дараагаар нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэлээ.



Хүрээ зуслангийн ерөнхий байдал




Зураг 1. Хүрээ зуслан-I дурсгалт газрын ерөнхий дэвсгэр зураг



Зураг 2-4. Хурээ зуслангийн язгууртны тахилын байгууламжийн малтлага судалгааны ерөнхий байдал



Хүрээ зуслан -I, Тахилын хашлага №14



Зураг 5. Хүрээ зуслан-I, Тахилын хашлага №14 –ийн ерөнхий дэвсгэр зураг